3.2 Зөвшөөрөл хүссэн өргөдлийг буу зэвсэг болон тэсэрч дэлбэрэх бодист хяналт тавих эрх бүхий байгууллага, Батлан хамгаалах яам, Тагнуулын ерөнхий газар болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимд гаргаж зохих зөвшөөрлийг авсан байна.

3.3 Энэхүү шаардлагуудыг биелүүлээгүй тохиолдолд хатуу шийтгэл ноогдуулна.

3. Arms and explosives requirements

3.1 The import, export and trans-shipment of all arms, explosives, component parts, munitions and weapons including swords, sword-sticks, kukris, parangs, daggers, spearheads, toy pistols, airguns, etc are strictly controlled.

3.2 Applications should be made to the appropriate authority on arms and explosives, Ministry of Defense, General Intelligence Agency and Mongolian National Chamber of Commerce and Industry and permits must be obtained.

3.3 Severe penalties are provided for non-compliance of the requirements.

4. Агаарын хөлөгт аюултай бараа тээвэрлэхэд тавигдах шаардлагууд

4.1 Ерөнхий зөвшөөрлийг Олон улсын иргэний нисэхийн Конвенцийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх тухай Annex 18-ын хүчинтэй хэвлэлийн шаардлагуудыг хангасан агаарын тээвэрлэгчдэд Гаалийн удирдах газраас олгоно. Агаарын тээвэрлэгч нь тээвэрлэхийг хүсэж буй аюултай ачааны талаар тодорхой мэдээллийг багтаасан өргөдлөө Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад ирүүлнэ. Уг өргөдөлд замын дагалдах хуудас болон мэдүүлэх хуудсыг хавсаргасан байна.

4.1 General permission is given to airlines by the Customs Authority subject to compliance with the current edition of ICAO Annex 18 to the Convention on International Civil Aviation relating to the Safe Transport of Dangerous Goods by Air. Operators who wish to carry dangerous goods should apply to the Director General of Civil Aviation Authority of Mongolia, giving relevant details of the consignment. Application must be supported by an airway bill or invoice to that effect.

4.2 Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх тухай ICAO-ийн техникийн зааварчилгааны Бүлэг 2.1 (Doc 9284) болон аюултай ачааг тээвэрлэх журмын Бүлэг 3.3-т заасны дагуу аюултай ачааг тээвэрлэхийг хориглоно.

4.2 The transport of dangerous goods are prohibited according to the ICAO Technical instructions for the safe transport of dangerous goods by air Part 2.1 (Doc 9284) and the procedure for dangerous goods Part 3.3.

4.3 Холбогдох эрх бүхий байгууллагаас зохих хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөлтэй байна.

4.3 Special permit from appropriate authority should be obtained.

4.4 Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд хилийн мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

4.4 Border specialised inspection authority should be responsible for inspection of chemical dangerous and hazardous substances passing through the border.

Хэрэглэгчдийн шаардлагаас хамааран дараахь төрлийн PIB-ийг бэлтгэх боломжтой.

а) Аэродромын PIB

Аэродромын PIB нь сонгогдсон аэродромуудад хамааралтай NOTAM болон SNOWTAM-ыг агуулна.

b) Нислэгийн замын PIB

Нислэгийн замын PIB нь нислэгийн төлөвлөгөөнд багтах ерөнхий нислэгийн замд үндэслэсэн PIB бөгөөд нисэн өнгөрөх FIR болон сонгогдсон аэродромуудад хамааралтай NOTAM болон SNOWTAM-ыг агуулна.

c) Тодорхой нислэгийн замын PIB

Тодорхой нислэгийн замын PIB нь нислэгийн төлөвлөгөөнд багтах тодорхой нислэгийн нислэгийн замд үндэслэсэн PIB бөгөөд нислэгийн замаар үүсэх хонгилд багтах NOTAM болон SNOWTAM-ыг агуулна.

d) Тусгай бүсийн PIB

Тусгай бүсийн PIB нь хэрэглэгчийн сонгосон бүсэд багтах NOTAM болон SNOWTAM-ыг агуулна.

5.2 Internet self-briefing (https://briefing.ais.mn/AviWeb/login)-нд байршлаас үл хамааран төрөл бүрийн зөөврийн төхөөрөмж ашиглан нэвтрэх боломжтой. Энэ нь нисэх багт дараах боломжийг олгоно. Үүнд:

а) өөрийн шалгуурын дагуу PIB бэлтгэж авах;

b) нислэгийн төлөв байдлын талаарх мэдээлэл авах;

c) нислэгийн төлөвлөгөө өгөх.

5.3 Нислэгийн дараах мэдээллийн үйлчилгээ

Нислэгийн дараах мэдээллийн зорилго нь нисэх баг нислэгийн үеэр ажиглагдсан нислэгийн үйл ажиллагааны аюулгүй байдалд чухал байгууламжуудын дутагдал болон нисэх буудалд эсхүл түүний ойролцоо агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй ан амьтан байгаа талаар эдгээр байгууламжуудыг хариуцсан байгууллагад цаг алдалгүй мэдэгдэх явдал юм.

Нислэгийн дараах мэдээллийн үйлчилгээг Чингис хаан болон Буянт-Ухаа аэродромуудад үзүүлнэ.

Нислэгийн дараах илтгэх хуудсыг НМҮА-ны цахим хуудас руу нэвтрэн (https://www.ais.mn/preReport) бөглөж явуулах боломжтой. Мөн хэвлэмэл хуудсыг Чингис хаан ОУНБ дахь НМҮ-ний нэгжид биечлэн хүргэх, шуудангаар эсхүл aisbof@ncac.mn цахим шуудангийн хаягаар илгээж болно.

Depending on the requirements of users, following types of PIB can be prepared:

a) Aerodrome PIB

Aerodrome PIB contains NOTAM and SNOWTAM related to the selected aerodromes.

b) Normal route PIB

Normal route PIB is a bulletin based on a generalised route as contained in the flight plan. It contains NOTAM and SNOWTAM related to the crossed FIRs and selected aerodromes.

c) Narrow route PIB

Narrow route PIB is a bulletin based on the planned route from the related flight plan, and includes NOTAM and SNOWTAM related to the width of the corridor based on planned route as contained in the flight plan.

d) Special area PIB

Special area PIB contains NOTAM and SNOWTAM inside user-defined area.

5.2 Internet self-briefing (https://briefing.ais.mn/AviWeb/login) is location independent and can be accessed using a variety of different portable devices. It allows flight crews:

a) to obtain the relevant PIB according to the individual input criteria;

b) to obtain flight status;

c) to submit flight plan.

5.3 Post flight information service

The purpose of post-flight information is to ensure that inadequacies of facilities essential to the safety of flight operations, and the presence of wildlife on or around the airport constituting a potential hazard to aircraft operations, observed by flight crews during the flight, are reported without delay to the authority responsible for those facilities.

Post-flight information service is provided at the Chinggis khaan and Buyant-Ukhaa aerodromes.

Post-flight report form is available on the AIS web site (https://www.ais.mn/preReport) for the electronic submission. Printed forms can be delivered in person of the AIS unit at Chinggis khaan international airport or send an email to aisbof@ncac.mn.

6. Тоон өгөгдлийн багцууд

6.1 Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба нь дараах төрлийн тоон өгөгдлийн багцуудыг гаргадаг. Үүнд:

a) AIP-ын өгөгдлийн багц;

b) Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн багц;

c) Саадын өгөгдлийн багц;

d) Аэродромын зураглалын өгөгдлийн багц;

e) Газрын гадаргын өгөгдлийн багц.

Тоон өгөгдлийн багцуудыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хамрах хүрээ, агуулгын дагуу хүргүүлэх боломжтой.

6.2 **AIP-ын өгөгдлийн багц**

AIP-ын өгөгдлийн багцыг AIXM 5.1-д суурилсан XML форматаар гаргана.

AIP-ын өгөгдлийн багц нь PANS-AIM ICAO Doc 10066-ийн 5.3.3.1.1-д заасан өгөгдлүүдийг агуулна.

AIP-ын өгөгдлийн багцыг иж бүрэн хэлбэрээр нь боловсруулах үеийн хүчин төгөлдөр мэдээллээр жил бүрийн эхний ажлын 5 хоногт багтаан боловсруулна.

AIP-ын өгөгдлийн иж бүрэн багц нь “AIPZM-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. DDMMMYYYY нь хүчин төгөлдөр болох огноо байна (Жишээ нь: AIPZM-07JAN2027.dat).

PANS-AIM ICAO Doc 10066-ын 5.3.3.1.1-д заасан өгөгдлүүдэд өөрчлөлт орох бүрт AIP-ын өгөгдлийн багцын өөрчлөлтийг боловсруулах ба зөвхөн өөрчлөлт орсон өгөгдлүүдийг агуулна.

AIP-ын өгөгдлийн багцын өөрчлөлт нь “AIPZM-AMDTNN-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. NN нь өөрчлөлтийн дугаар байна. DDMMMYYYY нь хүчин төгөлдөр болох огноо байна (Жишээ нь: AIPZM-AMDT01-18FEB2027.dat).

6.3 **Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн багц**

Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн багцыг AIXM 5.1 стандартад суурилсан XML форматаар гаргана.

Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн багц нь Үзүүлэлтэд суурилсан навигаци (PBN) нислэгийн журмын өгөгдөл, мэдээллийг агуулна.

Үзүүлэлтэд суурилсан навигаци (PBN) нислэгийн журмын өгөгдөл, мэдээлэлд өөрчлөлт орох бүрт иж бүрнээр боловсруулан гаргана.

Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн иж бүрэн багц нь “IFPZM-NN-YY-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. NN-YY нь оны эхнээс дараалан дугаарласан иж бүрэн багцын дугаар, DDMMMYYYY нь хүчин төгөлдөр болох огноо байна (Жишээ нь: IFPZM-01-26-JAN2027.dat).

6.4 **Саадын өгөгдлийн багц**

Саадын өгөгдлийн багцыг AIXM 5.1-д суурилсан XML, ESRI Shape болон CSV* форматаар гаргана.

Тэмдэглэл: Саадын өгөгдлийн багцыг хэрэглэгчийн хүсэлтийн дагуу CSV форматаар гаргаж өгнө.

Саадын өгөгдлийн иж бүрэн багц нь тухайн үүсгэж байгаа өдөр хүчин төгөлдөр байгаа бүх өгөгдлийг агуулсан байна.

Саадын өгөгдлийн иж бүрэн багцыг бүс (Бүс-1, Бүс-2, Бүс-3) тус бүрээр жил бүрийн эхний ажлын 5 хоногт багтаан гаргана.

Саадын өгөгдлийн иж бүрэн багц нь “O-AREAXZM-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. X нь саадын хамаарах бүсийн дугаар буюу “1”, “2”, “3” гэсэн утга, DDMMMYYYY хүчин төгөлдөр болох огноо байна. (Жишээ нь: O-AREA1ZM-18FEB2027.dat)

6. Digital data sets

6.1 The Aeronautical Information Services Division produces the following types of digital data sets:

a) AIP data set;

b) Instrument flight procedure data set;

c) Obstacle data set;

d) Aerodrome mapping data set;

e) Terrain data set.

The digital data sets can be provided with a scope and content meeting user requirements.

6.2 **AIP data set**

AIP data sets are provided in AIXM 5.1-based XML.

AIP data sets contain data on the subjects specified in Section 5.3.3.1.1 of PANS-AIM (ICAO Doc 10066).

The complete AIP data set is issued within the first 5 working days of each year, containing all data valid on the date of its creation.

The complete AIP data set is named in the format “AIPZM-DDMMMYYYY”, where DDMMMYYYY is the effective (e.g., AIPZM-07JAN2027.dat).

An AIP data set update shall be produced each time the data specified in 5.3.3.1.1 of PANS-AIM (ICAO Doc 10066) changes, and shall contain only the data that has changed.

The AIP data set amendment is named in the format “AIPZM-AMDTNN-DDMMMYYYY”, where NN is the amendment number and DDMMMYYYY is effective date (e.g., AIPZM-AMDT01-18FEB2027.dat).

6.3 **Instrument Flight Procedure data set**

The Instrument Flight Procedure data sets are provided in AIXM 5.1 based XML.

The Instrument Flight Procedure data sets contain data on the Performance-Based Navigation (PBN) flight procedures.

Whenever changes occur to performance-based navigation (PBN) flight procedure data and information, a complete data set shall be produced.

The complete instrument flight procedure data set is named in the format “IFPZM-NN-YY-DDMMMYYYY”, where NN-YY is the sequential dataset number from the beginning of the year, DDMMMYYYY is effective date (e.g., IFPZM-01-26-JAN2027.dat).

6.4 **Obstacle data set**

The Obstacle data sets are provided in AIXM 5.1-based XML, ESRI Shape and CSV* formats.

Note: The obstacle data set shall be provided in CSV format upon user request.

The complete obstacle data set contains all data valid on the date of its creation.

The complete obstacle data set is issued for each area (Area 1, Area 2 or Area 3) within the first 5 working days of each year.

The complete obstacle data set is named in the format “O-AREAXZM-DDMMMYYYY”, where X is the area number, i.e. “1”, “2” or “3”, and DDMMMYYYY is the effective date (e.g., O-AREA1ZM-18FEB2027.dat).

AIP-аар хэвлэн нийтэлсэн саадын мэдээлэлд өөрчлөлт орох бүрт саадын өгөгдлийн багцын өөрчлөлтийг боловсруулах ба зөвхөн өөрчлөлт орсон өгөгдлийг агуулна.

Саадын өгөгдлийн багцын өөрчлөлт нь “O-AREAXZM-AMDTNN-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. X нь саадын хамаарах бүсийн дугаар буюу 1, 2, 3 байна. NN нь өөрчлөлтийн дугаар байна. DDMMMYYYY нь хүчин төгөлдөр болох огноо байна (Жишээ нь: O-AREA1ZM-AMDT01-18FEB2027.dat).

Хэрэглэгчийн хүсэлтээр боловсруулах саадын өгөгдлийн багц нь бүсийн төрөл, хамрах хүрээ болон аэродромын байршил заах кодыг бүхий нэртэй байна (Жишээ: O-AREA2ZMUB-18FEB2027.dat).

An obstacle data set update shall be produced each time the obstacle information published in the AIP changes, and shall contain only the data that has changed.

The obstacle data set amendment is named in the format “O-AREAXZM-AMDTNN-DDMMMYYYY”, where X is the obstacle area number (1, 2 or 3), NN is the amendment number and DDMMMYYYY is the effective date (e.g., O-AREA1ZM-AMDT01-18FEB2027.dat).

Additionally, obstacle data sets produced upon user request are named by including the area type, the coverage, and the location indicator of the aerodrome (e.g., O-AREA2ZMUB-18FEB2027.dat).

6.5 **Аэродромын зураглалын өгөгдлийн багц**

Аэродромын зураглалын өгөгдлийн багцыг AIXM 5.1-д суурилсан XML болон ESRI Shape* форматаар гаргана.

Тэмдэглэл: ESRI Shape форматтай Аэродромын зураглалын өгөгдлийн багц нь тухайн аэродромын өгөгдлүүдийг агуулахаас гадна аэродромын саадын (Бүс-3) өгөгдлүүдийг багтаана.

Аэродромын зураглалын өгөгдлийн багцыг боломжит (ZMCD, ZMCK, ZMDZ, ZMKB, ZMKD, ZMMN, ZMUB) аэродром тус бүрээр боловсруулан гаргана.

Тухайн аэродромын зураглалын өгөгдлийн санд өөрчлөлт орох эсхүл өгөгдөл бүрдсэн үед Аэродромын зураглалын өгөгдлийн багцыг иж бүрэн хэлбэрээр гаргана.

Аэродромын зураглалын иж бүрэн өгөгдлийн багц нь “AMDBZMXX-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. ZMXX нь тухайн аэродромын байршил илтгэгч 4 үсгийн код байх DDMMMYYYY нь хүчин төгөлдөр огноо байна. (Жишээ нь: AMDBZMUB-18FEB2027.dat).

6.5 **Aerodrome mapping data set**

The Aerodrome mapping data sets are provided in AIXM 5.1 based XML and ESRI shape* format.

Note: The aerodrome mapping data sets in ESRI Shape format contain data for the specific aerodrome as well as aerodrome obstacle data (Area 3).

Aerodrome mapping data sets are produced for each aerodrome where feasible (ZMCD, ZMCK, ZMDZ, ZMKB, ZMKD, ZMMN and ZMUB) aerodromes.

A complete aerodrome mapping dataset is issued whenever changes occur in the aerodrome mapping database or when data compilation is complete.

A complete aerodrome mapping data set shall be named in the format “AMDBZMXX-DDMMMYYYY”, where ZMXX is the four-letter location indicator of the aerodrome concerned and DDMMMYYYY is the effective date (e.g., AMDBZMUB-18FEB2027.dat).

6.6 **Газрын гадаргын өгөгдлийн багц**

Газрын гадаргын өгөгдлийн багцыг GeoTIFF, IMAGE форматаар гаргана.

Газрын гадаргын өгөгдлийн багцыг

- Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дэх Бүс-1;
- ZMCK, ZMUB аэродромуудын Бүс-2.

Бусад аэродромуудын Бүс-2 болон Бүс-3-ын газрын гадаргын өгөгдлийн багцыг хэрэглэгчийн хүсэлтээр боловсруулах боломжтой.

Бүс-1-ийн газрын гадаргын өгөгдлийн багц нь “T-AREA1ZM-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. DDMMMYYYY нь өгөгдлийн багцыг боловсруулсан огноо байна (Жишээ нь: T-AREA1ZM-01FEB2027.dat).

Бүс-2-ын газрын гадаргын өгөгдлийн багц нь “T-AREA2ZMXX-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. ZMXX-ийн оронд тухайн аэродромын байршил илтгэгч 4 үсгийн код байх ба DDMMMYYYY нь боловсруулсан огноо байна (Жишээ нь: T-AREA2ZMCK-01FEB2027.dat).

Бүс-3-ын газрын гадаргын өгөгдлийн багц нь “T-AREA3ZMXX-DDMMMYYYY” форматтай нэртэй байна. ZMXX-ийн оронд тухайн аэродромын байршил илтгэгч 4 үсгийн код байх ба DDMMMYYYY нь боловсруулсан огноо байна (Жишээ нь: T-AREA3ZMCK-01FEB2027.dat).

6.6 **Terrain data set**

The data sets are provided in GeoTIFF, IMAGE format.

Terrain data sets are provided for

- Area 1 covering the entire territory of Mongolia;
- Area 2 of ZMCK, ZMUB.

Terrain data sets for Area 2 and Area 3 of other aerodromes can be produced upon user request.

The Area 1 terrain data set is named in the format “T-AREA1ZM-DDMMMYYYY”, where DDMMMYYYY is the date on which the data set was created (e.g., T-AREA1ZM-01FEB2027.dat).

The Area 2 terrain data set is named in the format “T-AREA2ZMXX-DDMMMYYYY”, where ZMXX is replaced by the four-letter location indicator of the aerodrome concerned and DDMMMYYYY is the date of creation (e.g., T-AREA2ZMCK-01FEB2027.dat).

The Area 3 terrain data set is named in the format “T-AREA3ZMXX-DDMMMYYYY”, where ZMXX is replaced by the four-letter location indicator of the aerodrome concerned and DDMMMYYYY is the date of creation (e.g., T-AREA3ZMCK-01FEB2027.dat).

6.7 **Түгээх**

Тоон өгөгдлийн багцыг Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-тэй хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр гэрээнд заасан нөхцөлөөр цахим хуудсаар дамжуулан авч ашиглах боломжтой.

6.7 **Distribution**

The Digital datasets can be obtained and used via the website under the conditions specified in a formal arrangement to be established with National Civil Aviation Center State Owned LLC.

Тоон өгөгдлийн багцын шалгах хуудсыг https://ais.mn/dataset цахим хуудсанд байршуулах ба сар бүрийн NOTAM-ын шалгах хуудсаар тухайн сард шинэчлэгдсэн тоон өгөгдлийн багцын дугаарыг мэдээлнэ.

Тоон өгөгдлийн багц бүр нь бүрэн бүтэн байдлыг шалгахад ашиглах CRC32 төрлийн алгоритм бүхий кодтой байна.

Тоон өгөгдлийн багцуудын талаарх мэдээлэл болон худалдан авах хүсэлтийг ажлын өдрүүдэд 00:00-08:00 (UTC) цагийн хооронд дараах хаягаар хандан авах боломжтой:

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба
Тоон мэдээллийн хэсэг
Буянт-Ухаа ОУНБ
Ш/х-59
Улаанбаатар 17121
Монгол Улс

Утас: 976-71283134
Факс: 976-70049838
Ц/ш: it-ais@ncac.mn
Ц/х: https://ais.mn/dataset

The checklist of digital data sets is published on the website https://ais.mn/dataset, and the numbers of the digital data sets updated during the month concerned are notified in the monthly NOTAM checklist.

Each digital data set is provided with a code based on a CRC32-type algorithm, which is used to verify its integrity.

Information on digital data sets and requests for their purchase may be obtained on working days between 00:00–08:00 (UTC) at the following address:

Aeronautical Information Services Division
Digital Data Section
Buyant-Ukhaa International Airport
P.O.Box-59
Ulaanbaatar 17121
Mongolia

Tel: 976-71283134
Fax: 976-70049838
E-mail: it-ais@ncac.mn
Web: https://ais.mn/dataset

GEN 3.4 ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Хариуцах байгууллага

1.1 Монгол Улсын Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ийн Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба нь GEN 3.4.2-т заасан хариуцлагын бүс дотор холбоо болон навигацийн үйлчилгээгээр хангах үүрэгтэй байгууллага юм.

Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба
Буянт-Ухаа ОУНБ
Ш/х-25
Улаанбаатар 17120
Монгол Улс

Утас: 976-71285050
Факс: 976-71281160
976-70049785
AFS: ZMUBYFYX
Ц/ш: cns_office@ncac.mn
Ц/х: http://cns.ncac.mn/

1.2 ICAO-гийн холбогдох баримт бичгүүд

Холбоо болон навигацийн үйлчилгээг ICAO-гийн дараах баримт бичгүүдэд заасны дагуу үзүүлнэ:

• Annex 10 - Нисэхийн цахилгаан холбоо

• Doc 8400 - Агаарын навигацийн үйлчилгээний журмууд -ICAO-гийн Товчлол ба кодууд (PANS-ABC)

• Doc 8585 - Агаарын хөлгийн агентлагууд, Нисэхийн удирдах байгууллагуудын таних тэмдэгүүд

• Doc 7910 - Байршил заах кодууд

• Doc 7030 - Бүс нутгийн нэмэлт журмууд

1.3 Annex 10-аас зөрүүтэй байдлуудыг GEN 1.7 дэд хэсэгт нарийвчлан үзүүлнэ.

2. Хариуцлагын бүс

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт холбооны үйлчилгээнүүдийг үзүүлнэ.

3. Үйлчилгээний төрлүүд

3.1 Радио навигацийн үйлчилгээ

Монгол Улсын НХҮ-ний нэгжүүдийн хариуцлагын бүсэд нислэг үйлдэж буй бүх агаарын хөлгүүд нь дараах төрлийн радио навигацийн туслах төхөөрөмжийг ашиглах боломжтой:

• Чиглүүлэгч радио дохиологч (NDB)

• Хэрэглэлээр буулт үйлдэх систем (ILS)

• Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч (VOR)

• Зай хэмжих төхөөрөмж (DME)

• Нарийвчлалтай ойртолтын налуу заагч

3.2 Дуун / өгөгдлийн холбооны үйлчилгээнүүд

Дуун холбооны үйлчилгээ

Нисэхийн станцууд нь өөр зааварчилгаа аваагүй тохиолдолд зарласан үйлчилгээ үзүүлэх цагуудын турш давтамжуудад байнгын хяналт тавьж ажиллана. Дэлгэрэнгүй мэдээллийг AD 2.18 дэд хэсэгт үзүүлсэн.

Агаарын хөлөг нь нисэж буй бүсийнхээ агаар-газрын удирдлагыг хариуцсан радио станцтай тогтмол холбоо барих нь зүйтэй.

GEN 3.4 COMMUNICATION SERVICES

1. Responsible service

1.1 Communication, Navigation, Surveillance Services Division of National Civil Aviation Center SOLLC of Mongolia is the responsible authority for the provision of communication and navigation services within the area of its responsibility as indicated under GEN 3.4.2.

Communication, Navigation, Surveillance Services Division
Buyant-Ukhaa International Airport
P.O.Box-25
Ulaanbaatar 17120
Mongolia

Tel: 976-71285050
Fax: 976-71281160
976-70049785
AFS: ZMUBYFYX
E-mail: cns_office@ncac.mn
Web: http://cns.ncac.mn/

1.2 Applicable ICAO documents

The service is provided in accordance with the provisions contained in the following ICAO Documents:

• ICAO Annex 10 - Aeronautical Telecommunications

• Doc 8400 - Procedures for Air Navigation Services-ICAO Abbreviations and Codes (PANS-ABC)

• Doc 8585 - Designators for Aircraft Operating Agencies, Aeronautical Authorities and Services

• Doc 7910 - Location Indicators

• Doc 7030 - Regional Supplementary Procedures

1.3 Differences to ICAO Annex 10 are detailed in subsection GEN 1.7.

2. Area of responsibility

Communication services are provided for the entire territory of Mongolia.

3. Types of service

3.1 Radio navigation service

The following types of radio navigation aids are available for any aircraft operating within the area of responsibility of Mongolian ATS units:

• Non-directional Radio Beacon (NDB)

• Instrument Landing System (ILS)

• VHF Omnidirectional Radio Range (VOR)

• Distance Measuring Equipment (DME)

• Precision Approach Path Indicator (PAPI)

3.2 Voice / data link services

Voice service

The aeronautical stations maintain a continuous watch on their stated frequencies during the published hours of service unless otherwise notified. The details are given in subsection AD 2.18.

An aircraft should normally communicate with the air-ground control radio station that exercises control in the area in which the aircraft is flying.

Өгөгдлийн холбооны үйлчилгээ

Нисэхийн суурин станцуудын хооронд агаарын навигацийн аюулгүй ажиллагаа болон тогтмолжилттой холбоотой мэдээ солилцоход энэхүү үйлчилгээг ашиглана.

AFS шугамуудыг GEN 3.4.5-д зургаар харуулсан.

AFS үйл ажиллагаануудыг Олон улсын иргэний нисэхийн конвенцийн Annex 10, Боть 2-т заасан холбооны журмыг баримталж явуулна.

Мэдээний текст нь 1800 тэмдэгтээс хэтрэхгүй байна.

3.3 Радио нэвтрүүлгийн үйлчилгээ

Нислэг үйлдэж буй агаарын хөлөгт өргөн нэвтрүүлгийн дараах үйлчилгээнүүдийг үзүүлнэ:

a) VOLMET өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг GEN 3.5.7-д заасны дагуу нислэг үйлдэж буй агаарын хөлөгт үзүүлнэ;

b) Хэт өндөр давтамжийн (VHF) Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ (ATIS)-г Буянт-Ухаа ОУНБ болон Чингис Хаан ОУНБ-д үзүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг AD 2.18 дэд хэсэгт үзүүлсэн.

3.4 Ашиглагдаж буй хэл (үүд)

Нисэхийн холбооны үйлчилгээнүүдэд монгол болон англи хэлийг ашиглана.

3.5 Дэлгэрэнгүй мэдээллийг авах хэсэг

Нислэгийн замын хөдөлгөөнд ашиглах төрөл бүрийн байгууламжуудын дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2-ын ENR 4 хэсгээс харж болно.

Аэродром тус бүрт ашигладаг байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3 (AD)-ийн холбогдох хэсгүүдээс харж болно. Нэг байгууламжийг нислэгийн замын хөдөлгөөн болон аэродромын аль алинд ашиглах тохиолдолд дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 2 (ENR) ба Бүлэг 3 (AD)-ийн холбогдох хэсгүүдэд үзүүлнэ.

4. Шаардлага болон нөхцөлүүд

Хэт өндөр давтамж (VHF) болон өндөр давтамжийн (HF) станцууд нь Төв, Мөрөн, Дорнод, Говь, Алтай болон Баян секторуудад 24 цагийн турш ажиллахаас гадна хуваарьт нислэгтэй орон нутгийн нисэх буудлуудад захиалгаар ажиллана. Өндөр давтамжийн станц нь зөвхөн RDARA давтамжууд болон AM горимд ажиллана. Нэг хажуугийн зурвастай радио дамжуулагч, MWARA болон SELCAL байгууламж одоогоор байхгүй.

Data link service

This service is provided for the exchange of messages related to the safety and regularity of air navigation between aeronautical fixed stations.

AFS circuits are illustrated in GEN 3.4.5.

AFS operations are applied in principle the communication procedure of Volume 2 of ICAO Annex 10 to the Convention on International Civil Aviation.

The text of an individual message does not exceed 1800 characters.

3.3 Broadcasting service

The following broadcasts are available for aircraft in flight:

a) VOLMET broadcasts are available for aircraft in flight as described in GEN 3.5.7;

b) VHF Automatic Terminal Information Service (ATIS) is provided at Buyant-Ukhaa International Airport and Chinggis Khaan International Airport. The details are given in subsection AD 2.18.

3.4 Language(s) used

Mongolian and English are used in aeronautical communication services.

3.5 Where detailed information can be obtained

Details of the various facilities available for the en-route traffic can be found in Part 2, ENR 4.

Details of the facilities available for the individual aerodromes can be found in the relevant sections of Part 3 (AD). In cases where a facility is serving both the en-route traffic and the aerodromes, details are given in the relevant sections of Part 2 (ENR) and Part 3 (AD).

4. Requirements and conditions

VHF and HF are available H24 from Central, Muren, Dornod, Gobi, Altai and Bayan sectors, and are available at national airports for scheduled flights on request. HF is only available on RDARA frequencies, and in AM mode. Single side band transceivers, and MWARA and SELCAL facilities are not yet available.

GEN 4. АЭРОДРОМ БА АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖУУД

GEN 4.1 АЭРОДРОМ/ХЭЛИПОРТЫН ХУРААМЖУУД

Агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчдэд ноогдуулах аэродромын үйлчилгээний хураамжуудыг дараах хэлбэрээр тогтоосон. Үүнд:

1. Буултын хураамж
2. Зогсоолын хураамж
3. Ангарын хураамж
4. Хүзүүвчний хураамж
5. Зорчигч үйлчилгээний хураамж
6. Карго терминалын үйлчилгээний хураамж
7. Бусад хураамжууд

Тэмдэглэл:

Орон нутгийн нислэг үйлдэх үндэсний болон гадаадын агаарын тээвэрлэгчдэд үзүүлэх дээрх аэродромын үйлчилгээний хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нэмж тооцно.

Чингис хаан ОУНБ-д (ZMCK) олон улсын нислэг үйлдэх үндэсний агаарын тээвэрлэгчдэд үзүүлэх дээрх аэродромын үйлчилгээний хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нэмж тооцно.

Чингис хаан ОУНБ-д (ZMCK) олон улсын нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчдэд үзүүлэх дээрх үйлчилгээний хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) тооцохгүй.

Буянт-Ухаа ОУНБ-д (ZMUB) нислэг эхлэхээс ажлын 1 өдрийн өмнө хүсэлтээ ирүүлсэн захиалгат нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгүүдэд үзүүлэх үйлчилгээний хураамж 100 хувиар нэмэгдэнэ.

Чингис хаан ОУНБ-д (ZMCK) нислэг эхлэхээс ажлын 1 өдрийн өмнө хүсэлтээ ирүүлсэн захиалгат нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгүүдэд үзүүлэх үйлчилгээний хураамж 50 хувиар нэмэгдэнэ.

Буянт-Ухаа ОУНБ-д (ZMUB) нислэг эхлэхээс 6-аас багагүй цагийн өмнө хүсэлт ирүүлсэн захиалгат нислэг үйлдэх гадаадын агаарын тээвэрлэгчдийн агаарын хөлгүүдэд үзүүлэх үйлчилгээний хураамжийг 150 хувиар нэмэгдүүлнэ.

Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журмын 5 дугаар бүлэгт заасны дагуу дараах төрлийн нислэгийг Чингис хаан ОУНБ-ын үйлчилгээний төлбөр, хураамжаас чөлөөлнө. Үүнд

- *Эрэн хайх, авран туслах нислэг;*
- *Агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн эсхүл ослын буулт;*
- *Шалгалтын нислэг (Холбоо навигаци, гэрэл суултын төхөөрөмж, агаарын хөлгийн болон нислэгийн журам зохиох гм.);*
- *Засгийн газар хоорондын хэлэлцээрээр үйлчилгээний төлбөр хураамжаас чөлөөлөгдсөн нислэг.*

GEN 4. CHARGES FOR AERODROMES AND AIR NAVIGATION SERVICES

GEN 4.1 AERODROME/HELIPORT CHARGES

The aerodrome charges are established and collected from the aircraft operators and include:

1. Landing charge
2. Parking charge
3. Hangar charge
4. Passenger boarding bridge charge
5. Passenger service charge
6. Cargo terminal charge
7. Other charges

Note:

Value Added Tax (VAT) is applicable for aerodrome charges from national and foreign airlines operating domestic flights.

Value Added Tax (VAT) is applicable for aerodrome charges from national airlines operating international flight Chinggis khaan (ZMCK) international airport.

Value Added Tax (VAT) is not applicable for aerodrome charges from foreign airlines operating international flight Chinggis khaan (ZMCK) international airport.

All charges shall be increased by 100% for permission for aircraft of foreign airline operating non-scheduled flight requested 1 working day prior to the intended flight at Buyant-Ukhaa (ZMUB) International Airport.

All charges shall be increased by 50% for permission for aircraft of foreign airline operating non-scheduled flight requested 1 working day prior to the intended flight at Chinggis khaan (ZMCK) international airport.

All charges shall be increased by 150% for permission for aircraft of foreign airline operating non-scheduled flight requested 6 hours before to the intended flight at Buyant-Ukhaa (ZMUB) International Airport.

The following flights shall be exempted from the Chinggis khaan international airport fees and charges in accordance with Article 5 of the Regulation on Paid Civil Aviation Services, Payment Amount and Revenue Expenditure:

- *Search and rescue flights;*
- *Landing of an aircraft due to unlawful interference or emergency;*
- Flight check (for communication, navigation and lighting equipment, aircraft and flight procedure design etc);
- *Fee exempted flights in accordance with treaties between Governments.*

1. Буултын хураамж

Эдгээр хураамжуудыг агаарын хөлгийн гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин (MCTOW)-д үндэслэн тогтоох бөгөөд нэгжийн үнийг тонн тус бүрээр бодно.

a) Чингис хаан ОУНБ

1. Landing charge

Charges are based on the aircraft maximum certificated take-off weight (MCTOW). Unit rate is established per tonne.

a) Chinggis khaan international airport

Олон улсын нислэгүүд International flights		Орон нутгийн нислэгүүд Domestic flights
965.6км-с дээш холын зайн нислэгт (тонн тутамд) Long distance flight more than 965.6km (per tonne)	965.6км-с дотогш ойрын зайн нислэгт (тонн тутамд) Flight within 965.6km (per tonne)	Тонн тутамд Per tonne
USD 18	MNT 17000	MNT 5500

b) Буянт-Ухаа ОУНБ

b) Buyant-Ukhaa international airport

Олон улсын нислэгүүд International flights			
Гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a foreign airline		Үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a national airline	
Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge	Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge
USD 16	USD 19	MNT 17000	MNT 20000

Орон нутгийн нислэгүүд Domestic flights	
Үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a national airline	
Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge
MNT 5500	MNT 6050

Тэмдэглэл: Өдрийн цагаар ойртолтын гэрлийн систем ашигласан тохиолдолд шөнийн хураамжаар тооцно.

Захиалгат нислэг үйлдсэн тохиолдолд хураамж болон үнэлгээг 15 хувиар нэмэгдүүлж тооцно.

Note: In case of using approach lighting system during daytime, night charge shall be imposed.

All charges shall be increased by 15% for services provided to aircraft operating charter flights.

c) Ханбумбат нисэх буудал

Оюу Толгой ХХК-ийн захиалгат нислэгээс бусад төрлийн, гадаадын болон үндэсний агаарын тээврийн компаниудын агаарын хөлгөөс буултын хураамжийг тооцож авна.

c) Khanbumbat airport

Landing fees will be charged from aircraft of foreign and national airlines, other than the chartered flights of Oyu Tolgoi LLC.

Гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a foreign airline		Үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a national airline	
Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge	Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge
USD 15	USD 20	MNT 5500	MNT 6500

Тэмдэглэл: Дээрх хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ороогүй тул НӨАТ нэмж тооцно.

Note: Value Added Tax (VAT) is not included in the above charges, so VAT is applicable.

d) Бусад нисэх буудлууд

d) Other airports

Олон улсын нислэгүүд International flights				
Аэродромууд Aerodromes	Гадаадын агаарын тээвэрлэгчид Foreign airlines		Үндэсний агаарын тээвэрлэгчид National airlines	
	Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge	Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge
Өлгий Ulgii	MNT 13500	MNT 16900	MNT 8800	MNT 10600
Мөрөн, Чойбалсан, Баянхонгор, Ховд болон Гурвансайхан Muren, Choibalsan, Bayankhongor, Khovd and Gurvansaikhan	MNT 25400	MNT 30500	-	-
Бусад Other	MNT 13500	MNT 16900	-	-

Орон нутгийн нислэгүүд Domestic flights		
Аэродромууд Aerodromes	Өдрийн хураамж Day charge	Шөнийн хураамж Night charge
Мөрөн, Чойбалсан, Баянхонгор, Ховд болон Гурвансайхан Muren, Choibalsan, Bayankhongor, Khovd and Gurvansaikhan	MNT 1800	MNT 2600
Бусад Other	MNT 1300	MNT 2200

Тэмдэглэл: Өдрийн цагаар ойртолтын гэрлийн систем ашигласан тохиолдолд шөнийн хураамжаар тооцно.

Дээрх хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ороогүй тул НӨАТ нэмж тооцно.

Note: In case of using approach lighting system during daytime, night charge shall be imposed.

Value Added Tax (VAT) is not included in the above charges, so VAT is applicable.

2. Зогсоолын хураамж

Зогсоолын хураамжийг орон нутгийн нисэх буудлуудад эхний 4 цагт ноогдуулахгүй. Зогсоолд зогссон хугацааг буулт хийсэн цагаас нисэн гарсан цаг хүртэлх хугацаагаар тогтооно.

a) Чингис хаан ОУНБ

2. Parking charge

Parking for the first 4 hours at domestic airports is free of charge. Time of parking is defined as a period of time passed from time of landing till time of departure.

a) Chinggis khaan international airport

Агаарын хөлгийн жин (тонн) Aircraft weight (tonne)	Хураамж Charge
	Цагийн (тонн тутмаас) Per hour (per tonne)
50 ба түүнээс бага / 50 or less	MNT 130
51-100	MNT 260
101 ба түүнээс дээш / 101 or more	MNT 390

Тэмдэглэл: Зогсоолын хураамжийг Чингис хаан ОУНБ-д эхний 2 цагт ноогдуулахгүй. Зогсоолд зогссон хугацааг буулт хийсэн цагаас нисэн гарсан цаг хүртэлх нийт хугацаанаас 15 минут хасч тогтооно.

Note: Parking for the first 2 hours at Chinggis khaan international airport is free of charge. Time of parking is defined as a period of time passed from time of landing till time of departure minus 15 minutes.

b) Буянт-Ухаа ОУНБ

b) Buyant-Ukhaa international airport

Агаарын тээвэрлэгч Airline	Агаарын хөлгийн жин (тонн) Aircraft weight (tonne)	Хураамж Charge	
		Хоногт Per day	Цаг (тонн тутмаас) Per hour (per tonne)
Гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a foreign airline	50 хүртэл / 50 or less	T*0.1*t*60%	USD 0.1
	51-100	T*0.2*t*60%	USD 0.2
	101-ээс дээш / 101 or over	T*0.3*t*60%	USD 0.3
Үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a national airline	50 хүртэл / 50 or less	T*130*t*60%	MNT 130
	51-100	T*260*t*60%	MNT 260
	101-ээс дээш / 101 or over	T*390*t*60%	MNT 390
Ерөнхий зориулалтын агаарын хөлөг General aviation	5.7 хүртэл / up to 5.7	T*65*t*60%	MNT 65
	5.7-оос дээш / 5.7 or over	T*130*t*60%	MNT 130

Агаарын хөлгийн зогсоолын төлбөр Parking charge	
Агаарын хөлгийн урт * далавчны урт /үржүүлэх/ Aircraft length * wing length /multiply/	Эхний 2 цагаас хойших 24 цаг тутамд ноогдох нэгж үнэ Price per unit for each 24 hours after the first 2 hours
1000м2 хүртэл / up to 1000m2	USD 50.50
1001m2-1500m2	USD 75.10
1501m2-2000m2	USD 100.00
2000м2-ээс дээш / 2000m2 or over	USD 100.00 + 4.95 100м2 тутамд эсвэл 2000м2-ээс дээш USD 100.00 + 4.95 for every 100m2 or over 2000m2

Хэрэв агаарын хөлөг “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын хаана ч 30 болон түүнээс дээш хоногоор зогссон тохиолдолд дараах төлбөрийг төлнө If the aircraft parks anywhere at Buyant-Ukhaa international airport for 30 days or more, the following charges apply	
Хоног / Days	24 цаг тутамд / every 24 hours
30-аас 59 хоног / 30-59 days	2 дахин нэмэгдүүлнэ / will be doubled
60-аас 89 хоног / 60-89 days	3 дахин нэмэгдүүлнэ / will triple every
90-ээс 119 хоног / 90-119 days	4 дахин нэмэгдүүлнэ / will quadruple
120-оос 149 хоног / 120-149 days	5 дахин нэмэгдүүлнэ / will increase fivefold
150-аас 179 хоног / 150-179 days	6 дахин нэмэгдүүлнэ / will increase sixfold
180-аас 209 хоног / 180-209 days	7 дахин нэмэгдүүлнэ / will increase sevenfold
210-аас 239 хоног / 210-239 days	8 дахин нэмэгдүүлнэ / will increase eightfold
240-өөс 269 хоног / 240-269 days	9 дахин нэмэгдүүлнэ / will increase ninefold
270 хоног болон түүнээс дээш / 270 days or over	10 дахин нэмэгдүүлнэ / will increase tenfold

Тэмдэглэл:

Зогсоолын хураамжийг Буянт-Ухаа ОУНБ-д эхний 2 цагт ногдуулахгүй.

Зогсоолд зогссон хугацааг буулт хийсэн цагаас нисэн гарсан цаг хүртэлх нийт хугацаанаас 15 минут хасаж тооцно.

Нислэгт гардаггүй, засвар үйлчилгээ хийх зорилгоор зогссон агаарын хөлгөөс цаг тутмын хураамжийг 50 хувиар бууруулан тооцно.

T - Агаарын хөлгийн хөөрөлтийн дээд жин

t - хугацаа (цагаар)

Note:

Parking for the first long-term 2 hours at Buyant-Ukhaa international airport free of charge.

Time of parking is defined as a period of time passed from time of landing till time of departure minus 15 minutes.

The charge per hour shall be decreased by 50% when the aircraft is on maintenance or not used in flight operations.

T - Maximum take-off weight of an aircraft

t - time (per hour)

c) Ханбумбат нисэх буудал

c) Khanbumbat airport

Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин (тонноор) Maximum certificated take-off weight (tonne)	Цаг, тонн тутмаас Per hour, per tonne	Хоногт Per day
50 хүртэл / 50 or less	MNT 150	T*150*t*60%
51-100	MNT 250	T*250*t*60%
101-ээс дээш / 101 or over	MNT 400	T*400*t*60%

Тэмдэглэл:

Зогсоолын хураамжийг Ханбумбат нисэх буудалд эхний 4 цагт ногдуулахгүй.

T - Гэрчилгээжсэн максимум хөөрөлтийн жин

t - хугацаа (цагаар)

Дээрх хураамжуудад нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ороогүй тул НӨАТ нэмж тооцно.

Note:

Parking for the first long-term 4 hours at Khanbumbat airport free of charge.

T - Maximum certificated take-off weight

t - time (per hour)

Value Added Tax (VAT) is not included in the above charges, so VAT is applicable.

3. Ангарын хураамж

Буянт-Ухаа ОУНБ-ын аэродром дотор байрлах ангарын хураамжийн мэдээллийг доорх хаягаар холбогдож авах боломжтой. Үүнд:

а) Хаяг: Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар
МИАТ Монголын Иргэний агаарын тээвэр
Буянт-Ухаа 45
Улаанбаатар 17120

3. Hangar charge

Charges of hangars located inside the aerodrome of Buyant-Ukhaa International Airport can be obtained from the following contacts:

a) Address: Maintenance & Engineering Organization
MIAT Mongolian Airlines
Buyant-Ukhaa 45
Ulaanbaatar 17120

Монгол Улс
Гэрчилгээ: EASA.145.0293, MCAR 145.001, Bermuda DCA Part 145, Бүгд Найрамдах Солонгос улсын MLTM, ISO 9001:2008

Утас: 976-70049654
Факс: 976-70049930
Ц/ш: amo@miat.com
Ц/х: www.miat.com/intro/amo

b) Хаяг: Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газар
Аэромонголиа ХХК
Хан-Уул дүүрэг, 21-р хороо
Буянт-Ухаа ОУНБ
Ш/х-105
Улаанбаатар-34
Монгол Улс
Гэрчилгээ: MCAR 145.1209, ISO 9001:2008

Утас: 976-71283212
Ц/ш: amo@aeromongolia.mn
SITA: ULNIBOM

c) Хаяг: Геосан ХХК
Наадамчдын гудамж
Хан-Уул дүүрэг, 21-р хороо
Улаанбаатар 17120
Монгол улс

Утас: 976-11-326730
Факс: 976-11-323297
Ц/ш: batamgalan@geosan.mn
Ц/х: www.geosan.mn

d) Хаяг: Блу Скай ХХК
Хан-Уул дүүрэг, 21-р хороо
Буянт-Ухаа ОУНБ
Буянт-Ухаа 45
Улаанбаатар 17120
Монгол улс

Утас: 976-71281166
Факс: 976-11-322857

Mongolia
Certifications: EASA.145.0293, MCAR 145.001, Bermuda DCA Part 145, The Republic of Korea MLTM, ISO 9001:2008

Tel: 976-70049654
Fax: 976-70049930
E-mail: amo@miat.com
Web: www.miat.com/intro/amo

b) Address: Maintenance Organization
Aero Mongolia Airlines
Khan-Uul district 21st khoroo
Buyant-Ukhaa International Airport
P.O.B-105
Ulaanbaatar-34
Mongolia
Certifications: MCAR 145.1209, ISO 9001:2008

Tel: 976-71283212
E-mail: amo@aeromongolia.mn
SITA: ULNIBOM

c) Address: Geosan LLC
Naadamchidiin street
Khan-Uul district, 21st khoroo
Ulaanbaatar 17120
Mongolia

Tel:976-11-326730
Fax:976-11-323297
E-mail:batamgalan@geosan.mn
Web:www.geosan.mn

d) Address: Blue Sky LLC
Khan-Uul district 21st khoroo
Buyant-Ukhaa International Airport
Buyant-Ukhaa 45
Ulaanbaatar 17120
Mongolia

Tel: 976-71281166
Fax: 976-11-322857

4. Хүзүүвчний хураамж

a) Чингис хаан ОУНБ

4. Passenger boarding bridge charge

a) Chinggis khaan international airport

Эхний 2 цагт First 2 hours	Эхний 2 цагийн дараа хагас цаг тутамд Every half hour after first 2 hours
USD 200	USD 40

Тэмдэглэл: Агаарын хөлөг тус бүрээс (холболтын цагаар)

b) Буянт-Ухаа ОУНБ

Хураамжийн үндэслэл: Агаарын хөлөг тус бүрээс холболтын цагаар.

Note: Per aircraft (per hour of using bridge)

b) Buyant-Ukhaa international airport

Rationale of charge: Per aircraft per hour of using bridge.

Агаарын тээвэрлэгч Airline	Эхний 2 цагт First 2 hours	Эхний 2 цагийн дараа хагас цаг тутамд Every half hour after first 2 hours
Гадаадын агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a foreign airline	USD 200	USD 40
Үндэсний агаарын тээвэрлэгчийн агаарын хөлгөөс From an aircraft of a national airline	MNT 350000	MNT 70000

5. Зорчигч үйлчилгээний хураамж

a) Чингис хаан ОУНБ

5. Passenger service charge

a) Chinggis khaan international airport

Энгийн зорчигчийн үйлчилгээний хураамж Economy passenger service charge		
Олон улсын нислэгийн зорчигч International flight passenger	Орон нутгийн нислэгийн зорчигч Domestic flight passenger	Дамжин өнгөрөх зорчигч (олон улс хоорондын) Transit passenger (between international)
USD 25	MNT 5500	USD 12.5 24 цаг доторх / within 24 hours

Тэмдэглэл: Дараах зорчигчдыг зорчигч үйлчилгээний хураамжаас чөлөөлнө.

- *Дипломат паспорттай албан ажлаар явж байгаа зорчигч*
- *Албан ажлаа гүйцэтгэж байгаа нисэх бүрэлдэхүүн*
- *Техникийн болон ослын буулт хийсэн агаарын хөлгийн зорчигчид*
- *2-с доош насны хүүхдүүд*

Note: Following passengers are free of passenger service charge.

- *Diplomatic passengers on official business*
- *Flight crew performing official duties*
- *Passengers of aircraft conducted emergency and technical landing*
- *Infants under the age of 2 years*

Зорчигчийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний хураамж Passenger security service charge Зорчигч тутамд / For each passenger	
Зөвхөн олон улсын нислэгт International flight only	USD 5 (ИНҮТ ТӨХХК-д 2.3 ам.долларыг зорчигч тутамд төлнө. “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-д 2.7 ам.долларыг зорчигч тутамд төлнө.) (USD 2.3/person to be paid to NCAC SOLLC. USD 2.7/person to be paid to NUBIA LLC.)

Тэмдэглэл: Дараах зорчигчдыг зорчигчийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний хураамжаас чөлөөлнө.

- *Албан ажлаа гүйцэтгэж байгаа нисэх бүрэлдэхүүн*
- *Ослын буулт хийсэн агаарын хөлгийн зорчигчид*
- *2-с доош насны хүүхдүүд*

Note: Passengers security service charge is not applicable to following persons.

- *Flight crew performing official duties*
- *Passengers of aircraft conducted emergency landing*
- *Infants under the age of 2 years*

b) Буянт-Ухаа ОУНБ

b) Buyant-Ukhaa international airport

Олон улсын нислэгийн зорчигч International flight passenger	Орон нутгийн нислэгийн зорчигч Domestic flight passenger
MNT 22000	MNT 5500

Тэмдэглэл: Дараах зорчигчдыг зорчигчийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний хураамжаас чөлөөлнө.

- *Албан ажлаа гүйцэтгэж байгаа нисэх бүрэлдэхүүн*
